



131

**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 48

Мандалговь

┌ Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах ┐
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 28,518,870 /хорин найман сая таван зуун арван найман мянга найман зуун дал/ төгрөгийн балансын үнэтэй, 621,680 /зургаан зуун хорин нэгэн мянга зургаан зуун ная/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилга байгууламжийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.


Хоёр. Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын дарга (Ё.Сайхантуяа)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1 Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах.
- 2.2 Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах.
- 2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.
- 2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Дэлгэрхангай сумын засаг даргын тамгын газрын дарга (Ё.Сайхантуяа)-д даалгасугай.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2020 оны 16 дугаар сарын
30-ний өдрийн 78 тогтоолын хавсралт



**Дэлгэрхангай сумын Засаг даргын тамгын газрын акталаж,
данснаас хасах барилгын мэдээлэл**

№	Барилга, байгууламжийн нэр	зориулалт	Хэмжих нэгж		Ашиглалта д орсон огноо	Ашиглалты н нийт хугацаа /жилээр/	Балансын үнэ	Хуримтлагдса н элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэм жих нэгж	Бист хэмжэ э					
1	Их өргөө	Үйлчилгээ	M2	89.2	2007.06.01	13	6,626,070	6,004,389.13	621,680.87
2	Конторын барилга	Үйлчилгээ	M2	96.2	1976.01.01	44	10,040,400	10,040,400	-
3	Моторын барилга	Үйлчилгээ	M2	44.8	1976.01.01	44	11,852,400	11,852,400	-
Нийт дүн									
							28,518,870	27,897,189.13	621,680.87
							/хорин найман сая таван зуун арван найман мянга найман зуун далан төгрөг/	/хорин долоон сая найман зуун ерэн долоон мянга нэг зуун наян есөн төгрөг арван гурван мөнгө/	/зургаан зуун хорин нэгэн мянга зургаа зуун наян төгрөг наян долоон мөнгө/